



 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР			
Бүртгэлийн дугаар -	Мөрдөж эхлэх огноо: 2023/08/03	Хувилбарын дугаар – 1.0	Хуудасны тоо – 6

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн
23/24 тоот тогтоолын 2 дугаар хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

Баримтын төрөл:	Журам
Нууцын зэрэглэлтэй эсэх:	Олон нийтэд хүртээмжтэй
Зохицуулах үйл ажиллагаа:	Компанийн хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох харилцааг тогтоох
Хариуцах нэгж/ажилтан:	Бүх нэгж/ Бүх ажилтнууд
Тус хувь хүртэх нэгж/ танилцах ажилтан:	Бүх нэгж/ Бүх ажилтнууд

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ.....	3
ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС САНАЛ ХҮСЭЛТ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ ШИЙДВЭРЛЭХ.....	4
ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА.....	4
ТАВ.БУСАД.....	4
ХАВСРАЛТ	

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр (цаашид “**Хөтөлбөр**”)-ийн зорилго нь “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “**Компани**”)-ийн хөрөнгө оруулагчдад Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, Компанийн засаглал, стратегийн хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэл, шаардлагатай бусад санхүүгийн мэдээллийг хүргэх, мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь энэхүү Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхийг зорьж ажиллана:
 - 1.2.1. Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв мэдээ мэдээллээр тухай бүр хангах;
 - 1.2.2. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;
 - 1.2.3. Компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох буюу Компанийн харьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчийг хангах;
 - 1.2.4. Компанийн засаглалын олон улсын зарчимд нийцсэн хөрөнгө оруулагчтай харилцах мэдээллийн цахим сувгийг бий болгох замаар ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэн болон Компанийн засаглалыг сайжруулах;
 - 1.2.5. Хөрөнгө оруулагчдыг Компанитай харилцах оролцоог нэмэгдүүлэх.
- 1.3 Энэхүү Хөтөлбөрийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны баталсан Компанийн Засаглалын Кодекс, Компанийн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам, загварын хүрээнд боловсруулав.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 2.1 Компани нь хөрөнгө оруулагчдад дараах мэдээллийг Компанийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүр хүргэнэ.
 - 2.1.1. Жилийн болон хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Компани нийтэлсэн тохиолдолд улирлын тайлан;
 - 2.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;
 - 2.1.3. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл;
 - 2.1.4. Зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;
 - 2.1.5. Хөрөнгө оруулагчдын ирүүлсэн санал хүсэлт, гомдол болон шийдвэрлэсэн байдал;
 - 2.1.6. Компанийн шаардлагатай бусад мэдээлэл.
- 2.2 Компани нь дараах хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана.
 - 2.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр Компанийн санхүүгийн гүйцэтгэл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “**ТУЗ**”), Гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;

- 2.2.2. Цахимаар болон биечлэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах;
- 2.2.3. Цахимаар болон биечлэн мэдээлэл хүргэх, солилцох;
- 2.2.4. Бусад арга хэрэгслээр мэдээлэл солилцох.

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС САНАЛ ХҮСЭЛТ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ

- 3.1 Хөрөнгө оруулагч нь санал хүсэлт, гомдлыг contact@lend.mn хаяг, Компанийн цахим хаягууд (Facebook, Intstagram, www.lend.mn хаяг)-аар дамжуулан цахимаар гарах, 77070101 тоот утсанд хандан амаар гаргах, эсхүл өөрийн биеэр бичгээр хүргүүлнэ.
- 3.2 Хөрөнгө оруулагч санал хүсэлт, гомдлоо өөрийн биеэр бичгээр Компанид хүргүүлэх тохиолдолд Хөтөлбөрийн 1 дүгээр хавсралтад заасан “Хөрөнгө оруулагчийн санал хүсэлт, гомдол гаргах маягт”-ын дагуу гаргана.
- 3.3 Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг тэр даруй ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь нөхцөл байдлыг тодруулж, Компанийн холбогдох албан тушаалтантай хамтран шийдвэрлэнэ.
- 3.4 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журам, Компанийн дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэх үүрэгтэй.
- 3.5 Компани нь энэхүү Хөтөлбөрийн 3.3-т зааснаар санал, хүсэлт, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв шаардлагатай бол Компанийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр тус хугацааг дахин ажлын 10 хүртэл хоногийн хугацаатайгаар сунгаж болно.
- 3.6 Компани нь Хөтөлбөрийн 3.3 дахь хэсэгт заасан санал хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа Хөрөнгө оруулагчийн и-мэйл хаягт, түүний цахим хаягт, түүнтэй утсаар холбогдон өгөх, эсхүл бичгээр хүргүүлнэ.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

- 4.1 Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнан ажиллана.
- 4.2 Энэхүү Хөтөлбөрийг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх бөгөөд Компанид учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

- 4.3 Компани болон Хөрөнгө оруулагчийн хооронд маргаан үүссэн тохиолдолд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв эс чадвал маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ТАВ. БУСАД

- 5.1 Энэхүү Хөтөлбөр нь Компанийн ТУЗ баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 5.2 Энэхүү Хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах эрх гагцхүү Компанийн ТУЗ-д хадгалагдана.
- 5.3 Энэхүү Хөтөлбөрийн хэрэгжилтэд Компанийн ТУЗ хяналт тавьж ажиллана.
- 5.4 Энэхүү Хөтөлбөрөөр зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж болон Компанийн дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.
- 5.5 Энэхүү Хөтөлбөрт иш татсан хууль тогтоомжийн аливаа зохицуулалтад өөрчлөлт орсноор холбогдох зүйл, хэсэг, заалтууд өөрчлөгдсөн нь энэхүү Хөтөлбөрийн тухайн зохицуулалт хүчингүй болох үндэслэл болохгүй.

-ЛЭНДМН ББСБ ХК-

“ЛэндМН ББСБ” ХК-ийн
“Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийн
Хавсралт № 1

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН САНАЛ ХҮСЭЛТ, ГОМДОЛ ГАРГАХ МАЯГТ”

“ЛЭНДМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн хөрөнгө оруулагч
овогтой (РД:.....) миний бие дараах
санал, хүсэлт, гомдлыг гаргаж байна.

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Гарын үсэг.....

Утас:.....

Оршин суугаа хаяг.....

.....

Э-мэйл хаяг:.....

Огноо: 20... оны сарын өдөр